

## ТАНИЛЦУУЛГА

*Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүчиний найдвартай, аюулгүй, тогтовортой байдлыг бүрэн хангах, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах чиглэл тусгагдсан.

Монгол Улсын эрчим хүчиний салбар нь газар нутгийн алслагдмал байдал, дэд бүтцийн хөгжлөөс хамааран төв, зүүн, баруун болон Алтай-Улиастай эрчим хүчиний сүлжээ гэсэн дөрвөн хэсгээс бүрдэж байна.

Улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчиний суурилагдсан хүчин чадлын хоёр хувийг усан цахилгаан станц үйлдвэрлэж байна. Эрчим хүчиний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит компани нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ төрийн эрх бүхий байгууллагаас тогтоосон үнэ тарифаар олон нийтэд борлуулдаг бөгөөд энэ нь цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, дамжуулах өргөөс бага байдаг.

Мөн зарим орон нутгийн татварын байгууллагаас сэргээгдэх эрчим хүчиний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компанийн цахилгаан станцын барилга, далан, ашиглалтын тунель, ажлын байр зэрэгт Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулж байгаа нь хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангахын тулд үндсэн үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай турбин, генераторын урсгал засваруудыг хийж үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангахад хүндрэл бэрхшээл тулгарсаар байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Нэмэгдсэн өргтийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.15-д төрөөс олгож байгаа төсвийн санхүүжилт, татаас, урамшууллыг нэмэгдсэн өргтийн албан татвар ногдуулах үйл ажиллагаанд нэгэн адил хамруулна гэж заасан нь тухайн хуулийн этгээдийн алдагдлыг нэмэгдүүлж, мөн хэмжээгээр хөрөнгө оруулалт санхүүжилт буурах, төдийгүй зээлийн буцаан төлөлтөд сөргөөр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлж байна.

2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр <http://www.lawforum.parliament.mn> сайтад байршуулсан бөгөөд ямар нэгэн санал ирээгүй болно.

Хууль санаачлагч